



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/171

Улаанбаатар хот

Г

Давтлага зохион байгуулах  
заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, “Боловсролын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 141 дүгээр тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2021 оны “Түр журмыг шинэчлэн батлах тухай” 41 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн суралцагчдад элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг халдварт хамгааллын дэглэм баримтлан сургуулийн орчинд 2020 оны 5 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн нэг сарын хугацаанд зохион байгуулсугай.
2. Сургуулийн орчинд элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлага зохион байгуулахад мөрдөх зааврыг хавсралтаар баталсугай.
3. Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлага зохион байгуулахтай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд тус тус үүрэг болгосугай.
  - 3.1. Давтлага зохион байгуулах хугацаанд сургуулийн гадаад, дотоод орчны эрүүл ахуй, аюулгүй байдалд тогтмол хяналт тавьж, халдварт хамгааллын дэглэмийг чанд мөрдөж, давтлагыг чанартай зохион байгуулахыг өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт;
  - 3.2. Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагад хамрагдаж байгаа суралцагчдын ирцийн талаарх мэдээллийг боловсролын салбарын мэдээллийн системд бүртгэн 7 хоног бүр мэдээлж байхыг Мэдээллийн технологи, статистикийн хэлтэс /О.Дүнжиннамдаг/-т;
  - 3.3. Давтлага зохион байгуулсан багш нарын ээлжийн амралтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахыг ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт;
  - 3.4. Энэхүү тушаалын хавсралтаар батлагдсан зааврыг ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад арга хэлбэрээр шуурхай хүргэж, давтлага зохион байгуулах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Бага, дунд боловсролын газар /Т.Ням-Очир/, аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга нарт;

D:alban bichig/tushaal

142110637

4. Сургуулийн орчинд халдвартархаас урьдчилан сэргийлэх орчин нөхцөл бүрдүүлж, эрүүл ахуй, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт зөвлөсүгэй.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаярт даалгасугай.

6. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Түр журам батлах тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/58 дугаар тушаал, “Хичээл, сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/120 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Боловсрол, шинжлэх ухааны сайдын  
2021 оны 05 дугаар сарын 10-ны  
өдрийн 11 дугаар тушаалын хавсралт

**ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТАД БЭЛТГЭХ ДАВТЛАГА  
ЗОХИОН БАЙГУУЛАХАД МӨРДӨХ ЗААВАР**

1. Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн төгсөгчдөд зориулан элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлага /цаашид "давтлага" гэх-/ыг ерөнхий боловсролын сургуулийн орчинд зохион байгуулахад энэхүү зааврыг мөрднө.
2. Давтлага зохион байгуулах хугацаанд Улсын онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаалаар баталсан "Коронавируст халдварт (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам", эрүүл мэндийн байгууллагаас коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх талаар гаргасан заавар, зөвлөмж болон энэхүү зааврыг тус тус баримтална.
3. Давтлага зохион байгуулахад сургуулийн захирал, сургалтын менежер, багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч тус тус тодорхой үүрэг хүлээн анги танхим, хүний нөөцийн болон орчны бэлэн байдлыг сайтар ханган, халдвараас урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдүүлж, тогтоосон дэгийг баримтлан ажиллана.
4. Давтлагыг хоёр ээлжээр зохион байгуулж болох бөгөөд нэг ээлж сургалтын 3 цагаас илүүгүй байна. Суралцагч элсэлтийн ерөнхий шалгалт өгөхөөр бүртгүүлсэн хичээл бүрээр давтлагад хамрагдах боломжийг бүрдүүлнэ.
5. Давтлага зохион байгуулах хугацаанд суралцагчдыг дотуур байранд байрлуулах эсэх асуудлыг орон нутгийн онцгой комисс шийдвэрлэнэ.
6. Сургуулийн захиргаа давтлага зохион байгуулахаас өмнө дараах бэлтгэлийг заавал хангасан байна:
  - 6.1. Халдвараас урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмж /амны хаалт зүүх, хүн хоорондын зайн барих, гар угаах, анги, танхимд агаар сэлгэлт хийх, халдвартгүйжүүлэлт хийх/, давтлагын үед баримтлах дэгийг хүртээмжтэй хэлбэрээр бэлтгэн байршуулах;
  - 6.2. Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаалаар баталсан түр журмын 2.1.8-д заасан түр тусгаарлах өрөөг бэлтгэх бөгөөд энэ өрөөг хариуцан ажиллах ажилтныг томилох;
  - 6.3. Сургуулийн удирдлагын баг 12 дугаар ангийн суралцагчдын эцэг эх, асран хамгаалагчийн хүсэлтийг судлан давтлагад хамрагдах суралцагчдын тоог гаргаж, давтлагын хуваарь гарган батлах;
  - 6.4. Давтлагад хамрагдах сурагчдын эцэг эх, асран хамгаалагчдад энэ зааврын 9.6-д заасан бэлтгэлийг хангах, давтлага зохион байгуулах хугацаанд тэдний гүйцэтгэх үүргийн талаар цахим хурал хийж урьдчилан танилцуулсан байх;
  - 6.5. Нэг анги танхимд 10-аас илүүгүй суралцагч байхаар тооцоолон танхимиг бэлтгэж, нэг ширээнд нэг суралцагч суухаар тооцон, ширээ хоорондын зайн 2 метрээс доошгүй зйтай байрлуулан тэмдэг, тэмдэглэгээ хийсэн байх;
  - 6.6. Сургуулийн гадаад, дотоод орчинд халдвартгүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, шаардагдах халдвартгүйжүүлэлтийн бодисыг давтлагын хугацаанд тасалдахгүй байх арга хэмжээ авах;

6.7. Давтлага зохион байгуулах анги танхимд орох, гарах хөдөлгөөнийг нэг чигийн урсалаар хөдөлгөөнийг давхцуулахгүй байхаар зохицуулж, тэмдэглэгээ, зураглал хийж байршуулах.

7. Халдвараас сэргийлэх зохион байгуулалтын дараах арга хэмжээг заавал хэрэгжүүлнэ:

7.1. Давтлагад хамрагдах суралцагчдад сургуулийн анги танхим, нийтийн эзэмшлийн газарт баримтлах дэгийг сайтар танилцуулж, мөрдүүлэх;

7.2. Давтлагын хугацаанд анги танхим, давхар бүрийн орчны эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, нийтийн эзэмшлийн газраар багш, суралцагчийн явсан хөдөлгөөнд хяналт тавьж ажиллах чиг үүргийг сургуулийн удирдлагын баг хариуцах;

7.3. Хичээлийн байранд багш, ажилтан, суралцагчийг амны хаалттай нэвтрүүлэх бөгөөд тэдний биеийн халууныг хэмжин, шаардлагатай тохиолдолд эмчийн үзлэгт хамруулах;

7.4. Биеийн халууныг хэмжиж, бүртгэл хийх үед амьсгалын замын цочмог халдварын шинж тэмдэг /толгой өвдөх, ханиах, найтаах, хамраас нус гоожих, биеийн халуун 38 хэмээс дээш байх/ илэрсэн тохиолдолд тэмдэглэл хөтлөн гэрт нь буцааж, эцэг эх, асран хамгаалагчид нь заавал мэдэгдэх;

7.5. Сургууль орчмын бүсэд цэвэрлэгээ, халдвартгүйжүүлэлтийг хуваарийн дагуу тогтмол хийж, гадны хүн нэвтрэх, хүн олноор цугларахгүй байх арга хэмжээ авах;

7.6. Сургуулийн нүхэн жорлон, ариун цэврийн өрөө, угаагуурт дараалал үүсгэхгүй байх зохицуулалт хийж, халдвартгүйжүүлэлтийг тогтмол хийх;

7.7. Ариун цэврийн өрөөнд саван, гар халдвартгүйжүүлэгч байнга байлгах;

7.8. Анги, танхимд 40 минут тутамд 10-15 минутын агаар сэлгэлт хийх;

7.9. Ээлж хооронд анги танхимд цэвэрлэгээ, агаар сэлгэлт хийх;

7.10. Анги, танхим болон хичээлийн хэрэглэгдэхүүн, эд зүйлсийн гадаргууг завсарлагаа болон ээлж солигдох хугацаанд цэвэрлэн халдвартгүйжүүлэх;

7.11. Багш, суралцагчид давтлагын үеэр анги танхимд хооллохгүй;

7.12. Анги танхимд хувцсаа нэг дор өлгөхгүй, сэгсрэхгүй байх зохицуулалт хийх;

7.13. Сургуулийн орчинд халдварын сэжигтэй тохиолдол илэрсэн тохиолдолд энэ зааврын 6.2-т заасан тусгайлан бэлтгэсэн өрөөнд тусгаарлаж, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаалаар баталсан журмын 6 дахь хэсэгт заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

8. Давтлагад хамрагдаж байгаа суралцагч дараах дэгийг баримтална:

8.1. Суралцагч нь давтлагад зөвхөн хуваарийн дагуу хамрагдах;

8.2. Давтлагын явцад амны хаалттай байх бөгөөд сургуульд нэвтрэхдээ биеийн халуунаа хэмжүүлэх;

8.3. Анги танхимд хуваарилсан суудалд сууж хичээллэх;

8.4. Давтлагын үеэр хэрэглэх ном, гарын авлага, хэрэглэгдэхүүнийг өөр хоорондоо солилцохгүй байх;

8.5. Завсарлагааны үеэр нийтийн эзэмшлийн талбай /коридор/, бие засах газарт бусадтайгаа 2 метрээс дотогш зайд ойртож харилцахгүй байх;

8.6. Биед ямар нэг өвчний зовуурь, шинж тэмдэг (халуурах, ханиалгах, ядарч сульдах, толгой өвдөх, булчингаар өвдөх, хоолой өвдөх, амьсгалын дээд зам үрэвсэх, үнэр, амт мэдрэхгүй, амьсгаадах, хоолны дуршил буурах, дотор муухайрах, бөөлжих, суулгах, сэтгэл санаа тогтвортгүй болох гэх мэт) илэрсэн тохиолдолд сургууль дээр ирэхгүйгээр багшдаа мэдэгдэж, эрүүл мэндийн байгууллагад хандах;

9. Давтлага зохион байгуулах хугацаанд сургуулийн удирдлага, багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчид дараах үүрэг хүлээнэ:

9.1. Сургуулийн орчны эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих үйл ажиллагааны нэгдсэн удирдлагыг сургуулийн захирал хариуцан ажиллах;

9.2. Анги танхимын агаар сэлгэлт, гар халдвартгүйжүүлэх, амны хаалт зөв хэрэглэх болон тогтоосон цагт амны хаалт сольж байгаа эсэх, сургуулийн орчин дахь хөдөлгөөний буртгэл болон цэвэрлэгээ, халдвартгүйжүүлэлтэд хяналт тавих ажлыг сургуулийн эмч хэрэгжүүлэх;

9.3. Давтлагын үед багш, ажилтан амны болон нүүрний хаалт тогтмол хэрэглэх;

9.4. Багш нь суралцагчтай адил тэгш хүндэтгэлтэй эелдэг харилцах, тэдний сурах үйлийг дэмжин урам өгөх, ялгаварлан гадуурхах, нэр төрийг гутаах үйлдэл гаргахгүй, багшийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллах;

9.5. Багш, ажилтан нь суралцагчид тогтоосон дэгийг баримталж буй байдал, тэдний биеийн эрүүл мэндэд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд сургуулийн эмчид мэдээлэл өгч ажиллах;

9.6. Эцэг эх, асран хамгаалагч хүүхдэдээ амны хаалт (2 цаг тутамд солихоор тооцож), нойтон салфетка, спиртэн суурьтай гар халдвартгүйжүүлэгч, гадуур хувцас хийх уут, хэрэглэсэн салфетка, амны хаалт хийх жижиг уут бэлтгэж өгнө. Давтлагад ирэхээс өмнө хүүхдэд цай, хоол заавал идүүлж дархлааг нь дэмжих;

9.7. Эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдийнхээ давтлагын хуваарьтай танилцаж, “Гэр-сургууль-гэр” гэсэн чиглэлийг мөрдүүлэх, анги танхимд мөрдсөн халдвар хамгааллын дэглэм /амны хаалт зүүх, хүн хоорондын зайд барих, гар угаах/-ийг сургуулийн гадна болон гэр бүлийн орчинд баримтлах;

9.8. Эцэг эх, асран хамгаалагч хүүхдийнхээ биеийн байдлыг тогтмол ажиглаж, өвдсөн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд багшид мэдэгдэж, дархлааг дэмжих;

9.9. Элсэлтийн ерөнхий шалгалттай холбоотойгоор багш тухайн хичээлээр суралцагчдад төлбөртэй давтлага өгөх, ном, гарын авлага, материал худалдан авахыг шаардах, борлуулахыг хориглоно.